



Улаанбаатар хот

9020010853 & 9123733

Нийслэлийн хүүхдийн сэргээн засах Эрүүл үрс
төвийн даргын 2021 оны 03 сарын 02 өдрийн
... дугаар тушаалын ... хавсралт

ӨВЧТӨН ШИЛЖҮҮЛЭХ ЖУРАМ

НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

- 1.1 Энэхүү журам нь Сэргээн засах төвөөс тусламж үйлчилгээ авсан үйлчлүүлэгчдэд /өвчтөн/ шаардлагатай эмнэлгийн тусламж үзүүлэх чадавх бүхий эмнэлэгт шилжүүлэх, яаралтай тусламжийг хугацаа алдалгүй авах, хүлээгдэл, чирэгдлийг бууруулахад оршино.
- 1.2 Сэргээн засах төвөөс шаардлагатай тохиолдолд өвчний эмнэлзүйн заавар, удирдамж, журмын дагуу лавлагаа шатлалын эмнэлэг, үндэсний төвүүдэд илгээнэ.
- 1.3 Эрүүл мэндийн байгууллага хооронд үйлчлүүлэгчийг шилжүүлэх үйлчилгээ нь дараах чиглэлтэй. Үүнд:
 - 1.3.1 Эмнэлгийн мэргэшсэн тусламж үйлчилгээ шаардлагатай тохиолдолд төрөлжсөн нарийн мэргэжлийн болон үндэсний төвүүдэд илгээх.
 - 1.3.2 Эмнэлэг хооронд илгээх /дүүргийн нэгдсэн эмнэлэг /
 - 1.3.3 Сэргээн засах төв, сувилал, хөнгөвчлөх асаргаа сувилгааны төв хооронд илгээх
 - 1.3.4 Яаралтай тусламж үзүүлэх шаардлагаар илгээх
 - 1.3.5 Эрүүл мэндийн сайд, Нийслэлийн эрүүл мэндийн газрын даргын тушаал, журмаар батлагдсан тусламж үйлчилгээ авах хуваарьт эмнэлгүүдэд шилжүүлэх.

ХОЁР. НАРИЙН МЭРГЭЖЛИЙН ЭМЧ, СУВИЛАГЧ НАРЫН ҮҮРЭГ

- 2.1 Сэргээн засах төвөөс өвчтөн, үйлчлүүлэгчийг ажлын цагаар яаралтай /улаан эрэмбэ/ журмаар шилжүүлэх тохиолдолд шаардлагатай тусламж үзүүлэн амин үзүүлэлтийг тогтворжуулж, тээвэрлэх бололцоотой болсон үед тусламж үзүүлсэн эмч дараагийн эмнэлэгт хүлээлгэж өгнө. Энэ тухай Сэргээн засах төвийн даргад мэдээлнэ.
- 2.2 Эрүүл мэндийн байгууллага хооронд өвчтөн үйлчлүүлэгчийг шилжүүлэхдээ үйлчлүүлэгчийг шилжүүлэх АМ13а маягыг хариуцсан нарийн мэргэжлийн эмч бөглөж, биеийн байдал оношилгоо шинжилгээ түүний өөрчлөлт эмч нарийн хамтарсан үзлэг, эмчилгээний үр дүн, авсан арга хэмжээ, шилжүүлэх

явцад биеийн байдалд учирч болох эрсдэл зэргийг үнэлэн тэмдэглэсэн мэдээллийн хамт шилжүүлнэ.

- 2.3 Сэргээн засах төв нь Нийслэлийн түргэн тусламжийн төв /103/ дуудлага өгч өвчтөн /сувицуулагчийг/ шилжүүлнэ.
- 2.4 Яаралтай бус /шар эрэмбэ/ тохиолдолд үйлчлүүлэгчийг түүний ар гэр эмнэлгийн байгууллагатай цахимаар болон утсаар мэдээлэл солилцон ажиллана.
- 2.5 Нарийн мэргэжлийн эмч нь өвчтөн үйлчлүүлэгчийг илгээсэн эрүүл мэндийн байгууллагаас өгсөн зөвлөмжийн дагуу өвчтөн үйлчлүүлэгчийг хүлээн авч шаардлагатай тохиолдолд хяналтад авч холбогдох эмчилгээ үйлчилгээний тасралтгүй байдлыг хангана.

ГУРАВ. ҮЙЛЧЛҮҮЛЭГЧИЙН ҮҮРЭГ

- 3.1 Өвчтөн, үйлчлүүлэгч тэдгээрийн ар гэр нь шилжүүлж буй тухайн эрүүл мэндийн байгууллагад холбогдох бичиг баримтаа /төрсний гэрчилгээ, эх хүүхдийн эрүүл мэндийн дэвтэр, амбулаторийн карт, холбогдох шинжилгээ/ бүрдүүлж өгнө.
- 3.2 Өвчтөн, үйлчлүүлэгч нь эмнэлгийн тусламж үйлчилгээ авсны дараа илгээсэн эмч, эмнэлэгт эргэн мэдээллээ ирүүлж цаашдын эмчилгээний асуудлыг шийдвэрлүүлнэ.